

ТҮҮХЭН БИЕ ХҮН ЧИНГИС ХААНЫ ӨНӨӨГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Удо Б. Баркманн¹

Үндэсний төрт улсууд үндэсний домог яриа, тодорхой бэлгэдэл, зан үйл зэргээс хууль ёсны эрхтэй гэдэгтээ итгэх итгэлийг олж авдаг нь орчин үеийн угсаатны зүйн ойлголтоор тэдгээр улс орны өвөрмөц онцлог нь болж байдаг ажээ. Монгол улсаас гадна Оросын Холбооны улс, БНХАУ-д амьдарч аж төрөн суугаа монгол угсаатнуудыг багтаасан монголчуудын соёлын хүрээний цөм болсон Монгол улсын хувьд ч ялгаагүй мөн л тийм байх аж.

Монгол үндэсний домог яриа нь аливаа үндэсний төрт улсад их бага ямар нэг хэмжээгээр байдагтай адил л бүтэцтэй байна. Түүнийг дараах байдлаар ангилж болно:

1. Уг гарал, 2. Түүхэн дээд өвөг, 3. Үндэс язгуур, 4. Алтан үе, 5. Айлган сүрдүүлэлт, доромжлол басамжлал, 6. Нутаг дэвсгэр, 7. Төрт улсын сэргэлт, 8. Төрт улсын шинэчлэлт.

Монголчууд, Монгол улсын хувьд дээрх ангилал нь доорхи агуулгатай байна:

„Монголчуудын уг гарал“-ыг Монголын нууц товчоо-нд Чингис хааны угийн бичигт тэмдэглэсэн бөгөөд нэг дэх үеийн элэнц өвөг нь „дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно“ ажээ. Харин монголчууд Чингис хааныг „түүхэн дээд өвөг“-оо гэж үзэх агаад монголчуудыг нэгтгэж, Их засаг хэмээх нэгдмэл нэг хуулинд захируулж, Их монгол улсыг байгуулсан агуу их гавьяа түүнд ногдоно. Урьд нь ч монголчууд төрийн олон бүтэцтэй байсан, гэхдээ түүгээр бүх монгол овог аймгийг нэгтгэн захирч чадаагүй юм.

„Үндэс язгуур“ гэж Тэмүүжиний андгай тавьсан ахан дүүсийн холбоог хэлж болох агаад эцсийн дүндээ тэр жинхэнэ цэргийн эрх мэдлийг тогтоож, хожмоо монголчуудыг цэрэг, улс төрийн хувьд нэгтгэсэн билээ. Тэр явцад „монголчууд“ хэл яриа, соёлын хувьд ижилсэн жигдэрч, олон овог нэгдэн „монгол“ угсаатан овог аймаг болсныг анзааралгүй өнгөрч боломгүй. Янз бүрийн ч гэсэн яс угсааны хувьд адил төстэй олон овог аймаг энэ маягаар ижилсэж, бие биедээ дасан дассаар яваандаа түүнийгээ ч хүлээн зөвшөөрөх болсон байна.

„Алтан үе“ гэдэг нь юутай ч түүхэн дэх хамгийн том дэлхийн эзэнт гүрэн болж, рах mongolica- г тогтоон түүхэнд анх удаа Европ, Азийг холбосон гүүрийг тавьсан Монголын их гүрний үе байсан нь дамжиггүй.

„Айлган сүрдүүлж, басамжлан доромжлох“ явдал Монголын түүхэнд цаг ямагт Хятад улс, хятадуудтай холбогдож иржээ. Сүрдүүлэг гэж юу болохыг монгол нүүдэлчид аль эрт дээр цагаас мэдэх болсон, гэхдээ Хятад ч бас умардын нүүдэлчдийн сүрдүүлгийг мэддэг байсныг анзаарахгүй байж үл болно. Юутай ч гэсэн Хятад умардынхны сүрдүүлгээс хамгаалж

1. Монгол Улсын Их Сургууль

Удо Баркманн

Их цагаан хэрмийг босгосон. Умардын нүүдэлчид, суурин хятад иргэдийн зөрчил тэмцэл нь эдийн засгийн шалтгаантай байв. Нүүдэлчид бэлчээрийг эрчимтэй бусаар ашиглан, малын энгийн нөхөн үйлдвэрлэлд тулгуурласан аж ахуй эрхэлж байжээ. Гар урлал бараг хөгжөөгүй тул бараа таваар үйлдвэрлэж байсангүй. Тийм болохоор нүүдэлчид хятадуудтай „малаа бараа таваараар“ сольж арилжихаас өөр аргагүй байж. Тэгвэл хятадууд өөрсдөө ч бас мал үржүүлдэг байсан тул нүүдэлчид шиг арилжаа солилцоо хийхээс өөр аргагүй байдалд орж байсангүй. Энэ нь нүүдэлчид Хятадын умардад дээрмийн аян дайн хийж, хариуд нь хятадууд цэргийн цохилт өгөх, нүүдэлчидтэй хийх худалдаагаа зохицуулах буюу бүрмөсөн зогсоох бодлогыг явуулахад хүргэж байв. Ар Монгол Манж Чин улсын бүрэлдэхүүн хэсэг болж байсан 1691-1911 он, нэн ялангуяа Чин улс ихэд хятадчилагдсан XX зууны эхэн үеийг монголчууд түүхийн үүднээс Хятад улс монголчуудын эрх чөлөөт амьдралд ноцтой аюул занал учруулсан цаг үе гэж дүгнэдэг. Тэгэхдээ Хятад ямагт хятадчилах, хүн амыг холилдуулан эрлийзжүүлэх бодлого явуулж байсныг Өвөр Монголын жишээ харуулна.

„Нутаг дэвсгэр“-ийг монголчууд Чингис хааны өөрсөнд нь үлдээж өгсөн газар нутагтай адилтган авч үздэг.

„Монголын төрт улсыг сэргээн байгуулсан“ нь дотоод, гадаад хүчин зүйлсийн харилцан үйлдлийн үр дүн болно. 1911 онд Ар Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялсан. Хувилгаан дүрүүдээрээ Чингисийн алтан ургийнхантай холбогдсон Богд гэгээний Засгийн газар Орос улстай нэгэн хэлэлцээрийг байгуулсан бөгөөд түүний үндсэн дээр Ар Монголын хүчирхэг автономит улс байгуулагдаж, де юре болон де факто Хятадаас салан тусгаарласан байна. 1921 оны „Ардын хувьсгал“, түүний дараах улс орны хөгжил ч бас монголчуудын өөрсдийнх нь улс төрийн ухамсарт үйл ажиллагаа, орос(зөвлөлт)-ийн бодлогын харилцан нөлөөллийн үр дүн байв. Монгол үндэсний төрт улс үүсэн бий болжээ. Сталин Ялт (1945)-ын хэлэлцээрээр Монгол улсыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэв. Түүний дүнд олон улсын эрх зүйн хувьд ч хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын хөгжлийн зам шуударч, 1961 онд НҮБ-д элссэнээр нь баталгаажсан юм. Монгол улс Зөвлөлт Холбоот Улсын нөлөөний хүрээнд үлдсэн ч Зөвлөлтийн тусламжтайгаар үндэсний төрт улсаа хэвээр нь хадгалж, өргөтгөн хөгжүүлж чадсан билээ.

„Монголын төрт улсын шинэчлэлт“ 1990 онд Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хэрэгжив. Монгол улс Зөвлөлт Холбоот Улс буюу Орос улсын нөлөө, эрхшээлээс ангижрав. Тус улс бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, тэгш эрхийг харилцан хүлээн зөвшөөрөх зарчмын үндсэн дээр хөршүүдтэйгээ тогтоосон харилцаагаа зохицуулах болов. Нууц товчоо (1991)-ны 750 жилийн ойгоор Чингис хаан түүх болон өнөөгийн монголчуудын сэтгэхүйд байр сууриа дахин эзлэв. Шашин, монголчуудын соёл, зан заншил дахиад л эрчимтэй хөгжиж эхэлсэн нь Зөвлөлтийн үед ч гэсэн соёлын дархлаагаа хадгалж байсныг нь тод томруун илтгэнэ.

Үндэсний домог яриа Монголын төрт улсад хууль ёсны эрхийн талаарх бодол төсөөллийнх нь нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна. Харин үр нөлөө нь улсын хил хязгаараас ч халип гарчээ. Тэр нь нийт монголчуудыг холбогч чухал холбоос болж бие биетэйгээ адил төстэй, ойрын холбоотой гэдгийг нь мэдрүүлж байна. Монгол улсад амьдарч буй монголчууд болон бусад газрын монголчуудын цөөнхийн гэрт ч юмуу тахилын ширээн дээр Чингис хааны зураг заларч байдаг нь хамгийн энгийн баримт болно. Бас хажууд нь Далай ламын зургийг залсан байх нь олонтаа. Монголчуудын „түүхэн дээд өвөг“ төвд гаралтай буддын шашны тэргүүний дэргэд заларч буй нь тэр. Өдгөө Монголд шарын шашны тухай ярьдаг хүнгүй шахам болжээ. Харин энэ завсар „Монголын бурханы шашин“-ы тухай ярих болсон агаад хэл ярианы энэ зохицуулалт гадаадын судлаачдын дунд ч бас хэрэгжиж эхлээд байгаа юм. Үндэсний домог ярианы зэрэгцээгээр Монголын бурханы шашин мөн л адил төстэй, ойрын холбоотой болохыг нь мэдрүүлэн улам улмаар монголчуудыг холбогч холбоос болон хөгжиж байгаа нь Улаанбаатар

дахь Гандан хийдэд монгол мөргөлчид улам их очдог болсноор илэрч байна. Монголын төрт улс хэдий чинээ хүчирхэгжиж, нөлөө нь ихэснэ, үндэсний домгийн элементүүдэд суурилсан үндэсний бахархлаа мэдрэх мэдрэмж нь төдийчинээ гүн хэвшин тогтоно.

Үндэсний төрт улсад хууль ёсны эрхтэй гэдэгтээ итгэх итгэл нь үндэсний домгийн зэрэгцээгээр бас түүхэн уламжлалын гинжин холбоон дээр суурилсан бэлгэдэл, зан үйл, залгамж чанарын талаарх төсөөлөлд тулгуурлана. 1992 онд батлагдсан үндсэн хуулинд бэлгэдлийн тухай заалт бий. Түүнд: „Монголын ард түмэн бид... төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөнө... Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.”² гэсэн буй. „Тулгар төр”, „Их цагаан туг” гэсэн нэр томъёонууд Чингис хааны түүхэнд хийж бүтээснийг, түүний үйл хэргийг шууд санагдуулдаг. Хэрэв үндсэн хуулинд „мөнх тэнгэр” гэсэн бэлгэдлийн тухай заасан байвал монголчууд Монголын хаадын илгээлт бичгүүдийн эхэнд гардаг „мөнх тэнгэрийн хүчин дор” хэмээх алдарт үгсийг аяндаа санана. Мөнх хааны нэгэн бичигт: „Мөнх тэнгэрийн хүчин-дор. Дээр гагц Мөнх тэнгэр, дор газар гагц эзэн Чингис хаан.”³ гэж бичсэн буй. Бас өөр олон бэлгэдэл байдгаас монгол цэргийн бэлгэдэл болсон „Их Хар Туг”, улмаар Чингис хааны дэлгэрүүлж, эзэнт гүрний албан ёсны бичгийн зэрэгт хүргэсэн монгол бичгийг нэрлэх нь зүйтэй. Монгол бичгийг дахин албан ёсны болгох өнөөгийн хүчин чармайлт нь бэлгэдлийн хүчийг нэмэгдүүлэх гэсэнтэй нь холбоотой. Нэг чухал бэлгэдэл бол Монголын мөнгөн дэвсгэрт дээрх Чингис хааны хөрөг юм. Энэ мөнгийг монголчууд өдөр бүхэн гартаа барьж байдаг. Уг хөрөг тэдэнд „төгрөг”-төө итгэх итгэлийг ямар нэг хэмжээгээр төрүүлж байдаг юм.

Зан үйл: Зан үйлийн саяхны жишээ нь эрдэмтдийн ажлын хэсгийн санал болгосны дагуу Монгол улсын ерөнхийлөгч зарлиг гаргаж Чингис хааны төрсөн өдрийг 1162 оны өвлийн тэргүүн сарын шинийн нэгнээр тогтоосон явдал мөн. Энэ өдрийг олон нийт Монгол бахархлын өдөр болгон тэмдэглэж байх ажээ. Өөр нэг жишээ нь гадаад орнуудын зочид төлөөлөгчид дипломат ёс жаягийн дагуу Сүхбаатарын талбай дахь Чингис хааны хөшөөнд мэхийн хүндэтгэл үзүүлдэг явдал юм. Хуримаа хийж буй хосууд ч бас өдгөө тэнд „түүхэн дээд өвөг”-төө гүн хүндэтгэлээ үзүүлж байна. Урьд нь тэд Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөдөг байсан билээ.

Улсын ерөнхийлөгчийн зарлиг нь түүхэн уламжлал, үйл явдлын холбосон залгамж чанарын тухай төсөөллийг бий болгож, зан үйл болгон хэвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байна. Тэдгээрээс: Чингис хааны дурсгалын цогцолбор байгуулах тухай 1997-04-08, Чингис хааны илгээсэн Монгол төрийн бичиг хэрэглэсний 800 жилийн ойг тэмдэглэх тухай (2003-06-25), “Монголын нууц товчоо”-г мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай (2004-02-18), Бурхан халдуны тухай (2010-09-20), Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэх тухай (2010-10-15) зэргийг дурьдах нь зүйтэй.

Үндэсний домог, бэлгэдэл, зан үйл, залгамж чанарын талаарх төсөөллийн харилцан нөлөөлөл нь орчин үеийн нийгэмд ч эх оронч үзэл, үндэсний эв нэгдэл, бахархал, тэмүүллийн үзэл санааг төлөвшүүлэхэд тус болох бусад олон хүчин зүйлийн нэг мөн юм. Даяарчлалын нөлөө, тус улсын газар зүйн байршлын үүднээс авч үзвэл монголчуудын соёлын хүрээний цөм болсон Монгол улсын хувьд ч юмуу Монгол улсын төрийн дуулалд гардагчлан: „дархан манай тусгаар улс, даяар Монголын ариун голомт”-ын хувьд энэхүү харилцан нөлөөлөл онцгой ач холбогдолтой. Түүнд нь „түүхэн дээд өвөг” Чингис хаан үнэлж баршгүй бэлгэдлийн хүчтэй түүхэн бие хүний хувьд онцгой үүрэг гүйцэтгэж байгааг нэг их онцлоод байх ч шаардлагагүй буй заа.

2. Монгол улсын Үндсэн хууль, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл, Долдугаар боть 1985.V сар-1992 он, Улаанбаатар 2010, S. 490-р тал үзмүү.
3. Ш. Бира, Монголын тэнгэрийн үзэл ба эдүүгээгийн дэлхийчлэлийн үзэл, *Өнөөдөр*, 2002.11.07.